



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний геологийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/275/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261628 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.БАТЦАЦРАЛ ТАНАА

2025.02.25 № 07/790
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний геологийн албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,401,739.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Гэрээний хугацаа дуусаад 10-12 жил болсон 1,124,480.7 мянган төгрөгийн геологийн судалгаа, шинжилгээний 2 ажил өнөөг хүртэл хэрэгжиж дуусаагүй;
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн ажлын техник хяналтын зардлыг бүртгэх тодорхой бодлого баталж, мөрдөөгүй, нэр бүхий 4 ажлын 1,802,523.6 мянган төгрөгийн гүйцэтгэлийг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан;
- Урсгал зардлаас бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль журмыг мөрдөөгүй нийт 283,235.4 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4, 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

хуулийн 3.1 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 39,240,799.0 мянган төгрөгийн өртөг бүхий 26 геологийн судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэж, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тушаалаар баталгаажуулж, биет бус хөрөнгөнд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үндэсний геологийн алба нь Геологийн баримтын төв архиваас судалгааны тайлан уншлага, тайлан хэвлэх, хувилах, гео мэдээллийн төвөөс мэдээлэл боловсруулах үйлчилгээ үзүүлэн, нийт 289,266.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Улсын төсвийн хөрөнгөөр 2020-2024 онд 77,369,9 км.кв талбайд хэрэгжиж буй 20 төслийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлж, Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 47.9 хувийг хамруулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

ATA9693 9066109
9023030583

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	100,234,165,725.00	101,131,952,778.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,051,225,618.51	17,846,711,335.65
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,051,225,618.51	17,846,711,335.65
31210	Төгрөг	3,051,225,618.51	17,846,711,335.65
31211	Төрийн сангийн харилцах	3,051,225,618.51	17,846,711,335.65
33	АВЛАГА	811,259.76	16,726,050.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	811,259.76	-
33500	Бусад авлага	-	16,726,050.25
33510	Байгууллагаас авах авлага	-	16,726,050.25
34	УРЬДЧИЛГАА	97,087,836,687.97	83,123,336,288.41
34600	Урьдчилж гарсан зардал	97,083,492,319.97	83,043,114,288.41
34710	Урьдчилгаа тооцоо	4,344,368.00	80,222,000.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	51,770,000.00
34714	Томилолтын урьдчилгаа	4,344,368.00	28,452,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	94,292,158.76	145,179,104.18
35400	Хангамжийн материал	94,292,158.76	145,179,104.18
35410	Бичиг хэргийн материал	8,106,600.00	3,149,500.00
35420	Аж ахуйн материал	56,581,845.39	46,758,641.39
35440	Түлш, шатах тослох материал	131,800.00	2,579,478.00
35470	Бусад хангамжийн материал	29,471,913.37	92,691,484.79
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	94,198,527,975.33	132,984,666,231.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	94,198,527,975.33	132,984,666,231.05
39200	Биет хөрөнгө	2,829,522,697.60	2,411,586,957.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,319,344,356.41	2,319,344,356.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	(847,010,187.33)	(888,370,590.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	177,500,000.00	162,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(160,833,333.36)	(148,866,666.72)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,870,372,442.37	1,898,356,112.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(736,599,010.02)	(1,151,445,883.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	304,702,796.80	353,177,596.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(171,518,468.18)	(204,233,244.65)
39214	Бусад үндсэн хөрөнгө	83,381,741.38	83,381,741.38
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,817,640.47)	(11,956,464.31)
39300	Биет бус хөрөнгө	91,369,005,277.73	130,573,079,274.03
39301	Програм хангамж	291,676,140.00	291,676,140.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(198,941,760.00)	(235,372,380.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	91,276,270,897.73	130,516,775,514.03
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	194,432,693,700.33	234,116,619,009.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,456,084,644.68	2,457,462,308.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,456,084,644.68	2,457,462,308.75
41300	Өглөг	2,456,084,644.68	2,457,462,308.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,148,922.68	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,441,703.00	17,213,740.00
41360	Бусад өглөг	2,434,494,019.00	2,440,248,568.75
41361	Байгууллагад төлөх өглөг	2,434,494,019.00	2,440,248,568.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	191,976,609,055.65	231,659,156,700.79
51	Засгийн газрын хувь оролцоо	191,976,609,055.65	231,659,156,700.79
51100	Засгийн газрын оруулсан капитал	21,299,375.00	21,299,375.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	21,299,375.00	21,299,375.00

51200	Хуримтлагдсан үр дүн	191,955,309,680.65	231,637,857,325.79
51210	Өмнөх үеийн үр дүн	170,661,440,080.60	192,688,091,061.99
51220	Тайлант үеийн үр дүн	21,293,869,600.05	38,949,766,263.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	194,432,693,700.33	234,116,619,009.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	24,770,827,944.81	42,810,011,802.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	542,114,345.00	734,210,074.00
120	Нийтлэг татварын бус орлого	542,114,345.00	734,210,074.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	542,114,345.00	734,210,074.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	193,860,235.00	289,266,779.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	348,254,110.00	444,943,295.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,228,713,599.81	42,075,801,728.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	24,149,797,415.00	41,707,218,167.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	24,149,797,415.00	41,707,218,167.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,916,184.81	368,583,561.56
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	307,673,109.76
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	78,916,184.81	60,910,451.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,476,958,344.76	3,860,245,538.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,476,958,344.76	3,860,245,538.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,689,742,631.13	3,419,191,973.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	826,465,157.32	1,043,310,598.30
210101	Үндсэн цалин	442,684,765.52	588,842,474.28
210102	Нэмэгдэл	176,011,265.62	230,928,424.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	104,306,000.00	150,190,000.00
210104	Урамшуулал	98,665,395.18	73,349,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,797,731.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,344,925.11	132,443,215.00
210201	Тэтгэврийн даатгал	70,833,816.69	87,662,811.58
210202	Тэтгэмжийн даатгал	8,333,390.29	10,558,761.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,561,112.25	9,197,818.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,601,509.72	5,004,764.85
210205	Эрүүл мэндийн даатгал	16,015,096.16	20,019,059.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,113,331.82	23,873,512.41
210301	Гэрэл, цахилгаан	4,115,483.73	11,927,471.54
210302	Түлш, халаалт	9,988,549.94	9,391,640.87
210303	Цэвэр, бохир ус	2,009,298.15	2,554,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	124,877,068.15	250,338,057.30
210401	Бичиг хэрэг	70,984,280.00	153,193,600.00
210402	Тээвэр, шатахуун	8,460,000.00	21,538,322.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,974,400.00	31,574,547.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,118,800.00	6,904,580.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,143,965.00	32,045,942.18
210408	Бараа материал акталсны зардал	7,865,623.15	4,751,065.30
2105	Нормативт зардал	-	1,113,225.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,113,225.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,896,562.00	234,506,931.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,850,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,301,500.00	2,653,970.00
210604	Урсгал засвар	80,745,062.00	231,852,961.00
2107	Томилолт, зочны зардал	86,356,204.00	150,300,325.00
210702	Дотоод албан томилолт	86,356,204.00	150,300,325.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	587,048,258.38	757,781,440.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	512,887,809.33	685,965,075.13
210803	Даатгалын үйлчилгээ	6,067,950.00	5,982,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,827.00	307,915.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	31,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	65,825,052.05	64,045,900.00
210807	Газрын төлбөр	430,620.00	430,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,350,000.00	1,018,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	852,641,124.35	825,524,669.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	164,505,336.20	284,284,839.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	964,000.00	10,415,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	687,171,788.15	530,824,830.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	787,215,713.63	441,053,564.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,384,337.00	36,648,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,627,137.00	10,700,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,757,200.00	25,948,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	697,831,376.63	404,404,664.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	501,284,247.63	18,712,384.01
213304	Хөрөнгийн	-	78,516,662.80
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,686,894.00	17,908,839.13
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	193,860,235.00	289,266,779.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	21,293,869,600.05	38,949,766,263.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	21,293,869,600.05	38,949,766,263.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	24,770,827,944.81	58,065,147,067.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	542,114,345.00	15,895,645,049.00
120	Нийтлэг татварын бус орлого	542,114,345.00	15,895,645,049.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	542,114,345.00	734,810,074.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	193,860,235.00	289,266,779.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	348,254,110.00	445,543,295.00
120009	Бусад орлого	-	15,160,834,975.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,228,713,599.81	42,169,502,018.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	24,149,797,415.00	41,707,218,167.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	24,149,797,415.00	41,707,218,167.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,916,184.81	462,283,851.56
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	307,673,109.76
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,015,154.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	76,901,030.81	154,610,741.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,419,578,221.71	3,481,913,574.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,419,578,221.71	3,481,913,574.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,632,362,508.08	3,040,860,009.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	816,605,887.93	1,044,624,108.64
210101	Үндсэн цалин	403,427,177.22	559,251,415.14
210102	Нэмэгдэл	212,030,225.55	263,667,864.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	104,838,466.75	148,719,553.65
210104	Урамшуулал	91,512,287.41	72,985,275.20
210105	Гэрээт ажлын хөлс	4,797,731.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,077,342.98	131,860,800.00
210201	Тэтгэврийн даатгал	79,378,642.98	89,665,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,424,600.00	10,548,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,739,900.00	5,274,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,684,800.00	5,274,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,849,400.00	21,097,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,113,331.82	24,863,512.41
210301	Гэрэл, цахилгаан	4,115,483.73	11,927,471.54
210302	Түлш, халаалт	9,988,549.94	10,381,640.87
210303	Цэвэр, бохир ус	2,009,298.15	2,554,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	111,125,480.00	208,375,327.82
210401	Бичиг хэрэг	73,997,480.00	139,956,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,591,800.00	22,996,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,974,400.00	31,574,547.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	330,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,231,800.00	13,518,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	96,196,562.00	234,506,931.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,150,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,301,500.00	2,653,970.00
210604	Урсгал засвар	80,745,062.00	231,852,961.00
2107	Томилолт, зочны зардал	76,693,954.00	150,300,325.00
210702	Дотоод албан томилолт	76,693,954.00	150,300,325.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	238,441,361.15	910,510,165.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	164,280,912.10	838,693,800.49
210803	Даатгалын үйлчилгээ	6,067,950.00	5,982,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,827.00	307,915.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	31,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	65,825,052.05	64,045,900.00
210807	Газрын төлбөр	430,620.00	430,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,350,000.00	1,018,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,108,588.20	335,818,839.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	163,144,588.20	325,403,839.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	964,000.00	10,415,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	787,215,713.63	441,053,564.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,384,337.00	36,648,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,627,137.00	10,700,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,757,200.00	25,948,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	697,831,376.63	404,404,664.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	501,284,247.63	18,712,384.01
213304	Хөрөнгийн	-	78,516,662.80
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,686,894.00	17,908,839.13
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	193,860,235.00	289,266,779.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,351,249,723.10	54,583,233,493.26
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,326,561,352.59	39,787,747,776.12
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,326,561,352.59	39,787,747,776.12
2200	Дотоод эх үүсвэрээр	22,326,561,352.59	39,787,747,776.12
223001	Бусад хөрөнгө	22,282,516,312.59	39,711,289,306.12
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	44,045,040.00	76,458,470.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(22,326,561,352.59)	(39,787,747,776.12)

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	24,688,370.51	14,795,485,717.14
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,026,537,248.00	3,051,225,618.51
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,051,225,618.51	17,846,711,335.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,299,375.00	-	170,661,440,080.60	170,682,739,455.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,299,375.00	-	170,661,440,080.60	170,682,739,455.60
Тайлант үеийн үр дүн	-	-	21,293,869,600.05	21,293,869,600.05
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,299,375.00	-	191,955,309,680.65	191,976,609,055.65
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	21,299,375.00	-	191,955,309,680.65	191,976,609,055.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	732,781,381.34	732,781,381.34
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,299,375.00	-	192,688,091,061.99	192,709,390,436.99
Тайлант үеийн үр дүн	-	-	38,949,766,263.80	38,949,766,263.80
2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	21,299,375.00	-	231,637,857,325.79	231,659,156,700.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,995,874,500.00	41,688,505,782.99	307,368,717.01	99.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,995,874,500.00	1,977,216,476.87	18,658,023.13	99.1

БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,959,225,600.00	1,940,567,576.87	18,658,023.13	99.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,054,886,200.00	1,044,624,108.64	10,262,091.36	99.0
Үндсэн цалин	578,439,600.00	559,251,415.14	19,188,184.86	96.7
Нэмэгдэл	325,583,400.00	263,667,864.65	61,915,535.35	81.0
Унаа хоолны хөнгөлөлт	99,708,800.00	148,719,553.65	(49,010,753.65)	149.2
Урамшуулал	51,154,400.00	72,985,275.20	(21,830,875.20)	142.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,860,800.00	131,860,800.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	89,665,400.00	89,665,400.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	10,548,900.00	10,548,900.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	5,274,400.00	5,274,400.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	5,274,500.00	5,274,500.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	21,097,600.00	21,097,600.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,839,200.00	24,863,512.41	4,975,687.59	83.3
Гэрэл, цахилгаан	13,297,100.00	11,927,471.54	1,369,628.46	89.7
Түлш, халаалт	13,987,700.00	10,381,640.87	3,606,059.13	74.2
Цэвэр, бохир ус	2,554,400.00	2,554,400.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	208,736,300.00	207,942,227.82	794,072.18	99.6
Бичиг хэрэг	139,956,500.00	139,956,500.00	-	100.0
Тээвэр, шатахуун	23,004,300.00	22,996,000.00	8,300.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,347,900.00	31,574,547.82	773,352.18	97.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	342,400.00	330,000.00	12,400.00	96.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,085,200.00	13,085,180.00	20.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	282,184,200.00	281,720,601.00	463,599.00	99.8
Багаж, техник, хэрэгсэл	27,992,200.00	27,983,670.00	8,530.00	100.0
Тавилга	19,620,000.00	19,230,000.00	390,000.00	98.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,688,800.00	2,653,970.00	34,830.00	98.7
Урсгал засвар	231,883,200.00	231,852,961.00	30,239.00	100.0
Томилолт, зочны зардал	43,450,800.00	43,301,280.00	149,520.00	99.7
Дотоод албан томилолт	43,450,800.00	43,301,280.00	149,520.00	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	153,336,600.00	151,410,765.00	1,925,835.00	98.7

үйлчилгээний төлбөр, хураамж				
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,390,800.00	79,594,400.00	1,796,400.00	97.8
Даатгалын үйлчилгээ	6,075,100.00	5,982,950.00	92,150.00	98.5
Тээврийн хэрэгслийн татвар	339,000.00	307,915.00	31,085.00	90.8
Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,100.00	31,100.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	64,045,900.00	64,045,900.00	-	100.0
Газрын төлбөр	430,500.00	430,500.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,024,200.00	1,018,000.00	6,200.00	99.4
Бараа үйлчилгээний бусад зардал	54,931,500.00	54,844,282.00	87,218.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	44,450,000.00	44,429,282.00	20,718.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,481,500.00	10,415,000.00	66,500.00	99.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,648,900.00	36,648,900.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	36,648,900.00	36,648,900.00	-	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,700,000.00	10,700,000.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,948,900.00	25,948,900.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,000,000,000.00	39,711,289,306.12	288,710,693.88	99.3
Бусад хөрөнгө	40,000,000,000.00	39,711,289,306.12	288,710,693.88	99.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,995,874,500.00	41,688,505,782.99	307,368,717.01	99.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,995,874,500.00	41,688,505,782.99	307,368,717.01	99.3
Улсын төсвөөс санхүүжих	41,995,874,500.00	41,688,505,782.99	307,368,717.01	99.3
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	35	-	100.0
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	17	17	-	100.0
Үйлчлэх ажилтан	16	16	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		348,814,384.76
УРСГАЛ ЗАРДАЛ		348,814,384.76
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		348,814,384.76
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		330,905,545.63
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		330,905,545.63
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		17,908,839.13
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		17,908,839.13
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		17,908,839.13
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		348,814,384.76
Нэмэлт санхүүжилтийн орлого		348,814,384.76
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		307,673,109.76
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		41,141,275.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нийт 15,330,248.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 4 алдааг залруулж, 2 зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг бэлтгэхдээ санхүүгийн тайлангийн тодруулгыг иж бүрэн бэлтгээгүй байна.	1	0.0			1	-			1		1	0.0
Агаарын геофизикийн геологийн судалгааны ажлын үлдэгдэл 15,160,835.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлэхдээ харилцагч байгууллагад урьдчилгаа төлбөр, өглөг үүсгэн бүртгэж, санхүүгийн тайланд нийт хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг хий өсгөн, санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаагүй байна.	1	15,160,835.0			1	15,160,835.0	1	15,160,835.0				
Мөнгөн гүйлгээний болон үр дүнгийн тайлангийн зардлын дандсын гүйцэтгэлийг нийт 47,795.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	47,795.9			1	47,795.9	1	47,795.9				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Ажилтнуудад олгосон нормын хувцасны ашиглалтын талаар баримтлах бодлого байхгүй, тайлант онд 6,000.0 мянган төгрөгийн дугуй, 51,017.2 мянган төгрөгийн нормын хувцсыг шууд зардлаар бүртгэсэн байна.	1	57,017.2			1	57,017.2	1	57,017.2				
Геологийн нэр томъёоны Англи-Орос-Монгол хэлний нэр хадмал толь бичиг зохиох 64,600.0 мянган төгрөгийн эх бэлтгэлийн ажлыг дуусаагүй ажил үйлчилгээний дансанд хуримтлуулан бүртгээгүй, шууд зардлаар бүртгэсэн байна.	1	64,600.0			1	64,600.0	1	64,600.0				
Үндсэн хөрөнгийн бүртгэлээр үлдэх өртөггүй боловч үйл ажиллагаанд хэвийн ашиглаж буй 38 ширхэг 1,247,720.1 мянган төгрөгийн элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, үндсэн хөрөнгийн бодит үнэ, ашиглах хугацааг тогтоолгоогүй, холбогдох байгууллагад хандаагүй байна.	1	0.0			1	0.0			1		1	0.0
Дүн	6	15,330,248.1	0	0.0	6	15,330,248.1	4	15,330,248.1	2	0.0	2	0.0

3.2 Аудитаар нийт 3,401,739.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,571,795.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 1,829,943.9 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүү

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

											лсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гео магнат ресурс ХХК-ийн 2012-2015 онд гүйцэтгэх гэрээний хугацаатай 584,785.0 мянган төгрөгийн, Жи Си Эс ХХК-ийн 2014-2016 онд гүйцэтгэх гэрээний хугацаатай 539,695.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон геологийн ажлууд өнөөг хүртэл хэрэгжиж дуусаагүй байна.	1	1,124,480.7			1	1,124,480.7						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын дагуу хугацаа хэтэрсэн геологийн ажлуудад үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэн, дотоод хяналтыг сайжруулсан боловч тухайн ажил гүйцэтгэх хугацааг бодитой тогтоож, гэрээний сунгалтыг тухай бүр хийж баталгаажуулж байх шаардлагатай байна.	1	0.0					1					
Салбарын ой тэмдэглэх шаардлага хангаагүй байхад Монгол Улсад геологийн алба үүсэж хөгжсөний 85 жилийн ойн арга хэмжээнд зориулан спорт, эрдэм шинжилгээний арга хэмжээнд нийт 119,977.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	119,977.6			1	119,977.6						
Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн ажлын техник хяналтын зардлыг бүртгэх тодорхой бодлого баталж, мөрдөөгүй байна. Тайлант онд хэрэгжиж дууссан геологийн ажлуудыг биет бус хөрөнгөөр орлого хүлээн зөвшөөрөхдөө, өмнөх онуудад зарцуулсан техник хяналтын 2 хувийн буюу 754,773.6 мянган төгрөгийн зардлыг өмнөх үеийн үр дүнд тохируулга хийн, бүртгэлд тусгаж байна. Мөн Геологийн төв лабораторид хэрэгжүүлж буй нэр бүхий 3 ажлын 1,800,592.5 мянган төгрөгийн, Дипирамид ХХК-ийн 1 ажлын 1,931.1 мянган	1	1,802,523.6					1	1,802,523.6				

төгрөгийн гүйцэтгэл санхүүгийн тайланд бүртгэлгүй байна.											
Шатахуун, бичиг хэрэг, нормын хувцас худалдан авахдаа холбогдох хууль журмыг мөрдөөгүй нийт 283,235.4 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.	1	283,235.4			1	283,235.4					
Геологийн баримтын төв архивын тооллогоор 15 тайлангийн ном, дэвтэр, 89 тайлангийн хавсралт зургууд тоологдоогүй, дутагдсан бөгөөд тооллогын комиссоос 1994 оноос эхлэн зарим нь тоологдоогүй байсан гэсэн тэмдэглэл хөтөлсөн байна. Тайлант онд дээрх дутагдсан хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	0.0					1				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй нийт 44,102.0 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэлд тусгасан байна.	1	44,102.0			1	44,102.0					
Зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулах зөвшөөрөл авалгүйгээр 27,420.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	27,420.3					1	27,420.3			
Аудитад төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохируулга тайлан, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан, улсын төсвийн орлого төвлөрүүлэлтэд тооцоо нийлсэн акт, кассын зарлагын нэгтгэл зэргийг гаргаж ирүүлээгүй тул, аудитын гүйцэтгэлийн үе шатанд төсвийн гүйцэтгэлийн тайлангийн үнэн зөвийг баталгаажуулж чадаагүй болно.	1	0.0					1				
Дүн	9	3,401,739.6	0	0.0	4	1,571,795.7	5	1,829,943.9		0.0	

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн асуудалд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр.дараах мэдээллийг дутуу болон огт байршуулаагүй байна.	1				1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Бичиг хэргийн материал, цэвэрлэгээний материал худалдан авах гэрээнд барааны чанар байдал, хэмжээ, үнийн талаар тусгаагүй, гэрээний хүчин төгөлдөр мөрдөх хугацаа зэргийг тодорхой байдлаар тусгаагүй байна.	1						1	-
Цалингийн тооцооны болон цалин олгох хүснэгтийг батлагдсан маягтаар гаргаж дарга, нягтлан бодогч нар баталгаажуулаагүй байна.	1						1	-
Дүн	3	-	-	-	1	-	2	-